

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 01

Мандалговь хот

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ц.МӨНХБАТ ТАНАА**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 10 дугаар хуралдааны /2022 оны 5 дугаар сарын 26 ны өдрийн/ тэмдэглэлээс:**

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:** МСҮТ-ийн хуучин хичээлийн байрны ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээллийг аймгийн ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн Л.Дарьбум танилцуулав.


Аймгийн Төсөв санхүү, эдийн засгийн хорооноос ” Монгол Улсын Их Хурлын 2018 оны 61 дүгээр тогтоолоор “Дундговь аймгийн МСҮТ-ийн хичээлийн (хуучин) байр, Дотуур байр (гуанзны барилга) холбогдох инженерийн шугам сүлжээний хамт 1,505,673,202 (нэг тэрбум таван зуун таван сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун хоёр) төгрөгний төрийн өмчөөс аймгийн өмчид, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, УИХ-ын тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор тус үндсэн хөрөнгийг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад тус тус шилжүүлсэн байна. Хөрөнгийг хүлээлцэх ажлыг хууль тогтоомжийн дагуу ажлын хэсэг байгуулан зохион байгуулахыг аймгийн Засаг даргад, хөрөнгийг бүртгэж тогтоол шийдвэрийн биелэлтийг ирүүлэхийг Сайнцагаан сумын ЗДТГ-ын даргад, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг ОНӨГ-т тус тус үүрэг болгосон байна. 2018 оны тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тус хөрөнгийг дансанд бүртгэж аваагүй гэж тайлагнасан байна. МСҮТөв нь шинэ байранд орохоос өмнө тус барилгыг хэвийн ашиглаж байсан бөгөөд хөрөнгийг ажлын хэсэг гаргаж хүлээлцсэн эсэх нь тодорхойгүй, дансанд хэзээ бүртгэсэн эсэх нь тодорхойгүй, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй зэрэг хариуцлагагүй байдал үүссэн байх магадлалтай байна Иймд тус барилгын өмчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтын байдалтай танилцан аймгийн ИТХ-ын ээлжит аравдугаар хуралдаан танилцуулна уу ” гэсэн албан тоотыг ирүүлсэн. Тус асуудлын хүрээнд тухайн барилгыг хүлээлцэх комиссыг аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн А/444 захирамжаар байгуулж хүлээлцсэн байна. Хичээлийн байрыг 2016 онд суллаад 2 жил ашиглаагүй бөгөөд хүлээлцэх үед 1 давхарын парны секцүүд хөлдөж хагарсан, цонх харгарсан, хичээлийн байрны үүдний дээвэр халцарч муудсан, хүзүүвчний урд хэсгийн дээврийн хар цаас хууларч ус дусдаг болсон. Данс бүртгэлд тусгагдаагүй хашаа хайс цэцгийн мандал зэргийг үндсэн хөрөнгөд бүртгэх тухай актанд тусгасан. Хичээлийн байрны чанар сайн, дотуур байрны чанар дунд байсан. Аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2021 онд ашиглалтгүй байгаа хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьсан бөгөөд энэ үеэр хуучин МСҮТ-ын байранд хяналт тавьсан байгаа. Тус барилга хараа хяналтгүй, нүднээс далд байгаа цонх хагарсан барилын чанар муудсан байсан бөгөөд Сайнцагаан сумын ЗДТГ-т зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр тус хичээлийн байран дээр ажилласан зүүн талд Хот тохижуулах газар орсон тул өнгө үзэмж сайжирсан байсан. Баруун талдаа цонх

хагарсан, цонхны чулуун тавцан хагарсан, гадна талын цэцгийн мандлын хашлага эвдэрсэн зэрэг хөрөнгө сүйтгэгдсэн байна ” гэж танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс гарсан зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавин ажиллах
2. МСҮТ-ийн хуучин хичээлийн байрны хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалт ямар цаг үед алдагдсан талаар олж тогтоож хариуцлага тооцох
3. Шинэ барилга ашиглалтанд ороод хуучин барилгаа эзэнгүй орхиж байгаа тохиолдол байгаад Орон нутгийн өмчийн газар хариуцлагатай ажиллах
4. Сумын өмч хамгаалах зөвлөлийн ажлыг сайжруулах
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого бүртгэлийн ажлыг чанартай үр дүнтэй зохион байгуулах” гэжээ

ДАРГА

  
С.ОД-ЭРДЭНЭ